

**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО
ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2022 ОНЫ ТАЙЛАН**

2023-01-10

Албан журмын даатгагчдын холбооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Удирдах зөвлөл батлагүй ч Гүйцэтгэх захирал ажлын албаны нэгжүүдийн төлөвлөгөөнд 2022 оны зорилтуудыг бүрэн тусган баталж Даатгалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиуд, бусад холбогдох эрх зүйн актуудад заасан чиг үүргийн гүйцэтгэлийг ханган ажиллалаа.

2022 онд, бичиг хэргийн эргэлт нийт 627, албан байгууллага, иргэдээс 203 албан бичиг, 93 өргөдөл, хүсэлтийг тус тус хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн албан байгууллага, иргэдэд нийт 331 албан бичиг явуулжээ.

Гүйцэтгэх захирлын 87 тушаал гарснаас 20 нь ажилтнуудыг томилох, чөлөөлөх тухай, 67 нь дотоод үйл ажиллагаа, нөхөн төлбөр олгохтой холбоотой тушаал байна. 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс Холбооны эд хөрөнгөд тооллого хийж эд хариуцагч тус бүрээр нүд үзэн тоолж эд хөрөнгийн картыг шинэчлэн бүртгэлжүүлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 67 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу 2022 оны 3 дугаар сард, Холбооны 2019-2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилт, түүний биелэлт нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудтай нийцэж байгаа байдал, тайлан мэдээ үнэн зөв эсэх, жолоочийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, мэдээллийн сангийн үйлчилгээ, программ хөгжүүлэлт, Сангийн шуурхай албаны үйл ажиллагаа зэргийг шалгаж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийн дагуу биелэлтийг цаг тухай бүрт Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газарт гарган өгч, Удирдах зөвлөлд танилцуулж ажиллалаа.

Албан журмын даатгагчдын холбоо 2020 оноос эхлэн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж үйл ажиллагаа ил тод сурталчлах ажлыг өөрийн Вэб хуудсаар дамжуулан хийж хэвшсэн бөгөөд www.ami.mn вэб хуудсанд хандсан байдлаас харвал 2022 онд 31009 удаа буюу давхардсан тоогоор 86187 удаа хандаж нийт 2,818170 хуудас материалтай танилцсан нь өнгөрсөн оны түвшинд байна.

Холбооны Удирдах зөвлөл 2022 онд, 3 удаа хуралдаж Холбооны 2021, 2022 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан, Жолоочийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн дүн, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийсэн дүн, Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 онд Холбооны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүн, шалгалтын мөрөөр цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө, банканд байршуулсан хөрөнгийн тухай, Холбооны орон нутаг дахь салбар, түүний орон тооны тухай, Даатгалын багц хууль, Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгөх санал, 2023 оны төсвийн төсөл болон бусад асуудлуудыг хэлэлцэж, хэлэлцсэн асуудалтай холбоотой 3 тогтоол баталсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 06 сарын хуралдаанд Холбооны 2012-2021 оны 10 жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулав.

2022 оны бичиг баримтуудыг хадгаламжийн нэгж үүсгэн орон нутаг дахь салбар болон ажлын албаны 172 боть баримтыг албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн архивт шилжүүлэв.

А. ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

НЭГ. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТАЛААР:

Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйл, Жолоочийн даатгалын тухай хуульд заасан үндсэн эрх, үүргийг хэрэгжүүлэхэд хөрөнгө, санхүүжилт чухал. Жолоочийн даатгалын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр нь Жолоочийн даатгалын сан юм. Жолоочийн даатгалын санг Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан эх үүсвэрээр бүрдүүлж, мөн хуулийн 23 дугаар зүйлд заасан зориулалтаар зарцуулж санхүүгийн тайлан гаргадаг.

Жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагааны зардлыг бүрэн санхүүжүүлж, ажилтнуудын цалин хөлс, Удирдах зөвлөлийн гишүүдийн урамшууллыг тооцож олгох, нийгмийн даатгалын байгууллагад сар бүрийн тайланг хугацаанд нь тайлагнаж, хөдөлмөрийн чадвараа түр алдсан зэрэг ажилтнуудад холбогдох тэтгэмжийн тооцоо нийлж нэхэмжилж, олгож ажиллалаа.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйл, Холбооны удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан эх үүсвэрээр Жолоочийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэх зорилтыг тайлант хугацаанд амжилттай хэрэгжүүллээ.

Жолоочийн даатгалын сангийн 2022 оны орлогын төлөвлөгөөг 2,438,200.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд, тайлант хугацаанд 2,541,020.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 4,2 хувиар буюу 102,8 сая төгрөг давуулж биелүүлсэн байна.

2022 онд жолоочийн даатгалын тухай хуулийн 18.1-д зааснаар нийт 155,232,728 төгрөг нэхэмжилсэн 47 өргөдөл хүлээн авч шаардлага хангасан 43 өргөдлийг хянан үзээд 140,087,485 төгрөгийн нөхөн төлбөр хохирогчдод олгов.

Жолоочийн даатгалын сан нь 2013-2022 онд нийтдээ 727,293,21.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг 289 даатгалын тохиолдлын хохирогчдод олгожээ.

Жолоочийн даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрөөс 76 хүний 148,1 сая төгрөг төлөгдөөгүй байгааг авлагаар тайланд тусгав.

Холбооны 2021 оны жилийн эцсийн, 2022 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүү, татварын тайлангуудыг нэгтгэн тогтсон хугацаанд холбогдох газруудад хүргүүлж тайлагналаа.

2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийсэн “Бэст фортуна аудит” ХХК -ийг Удирдах зөвлөлийн даргатай зөвшилцөж дахин сонгож 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэж, Санхүүгийн үйл ажиллагааны 2021 оны аудитын тайлан, дүгнэлтийг Удирдах зөвлөлд танилцуулж холбогдох байгууллагад хүргүүлж, өдөр тутмын “Өдрийн сонин”, Холбооны веб хуудсаар нийтэд мэдээллээ. Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг хуулийн 23 дугаар зүйлд заасан зориулалтаар зарцуулах тухай Удирдах зөвлөлөөс батлагдсан 2022 оны төсвийг 102,6

сая төгрөг буюу 6,6 хувиар хэмнэлттэй зарцуулсан бөгөөд зардлын гүйцэтгэл 1449871,3 мян. төгрөг болжээ.

ХОЁР. ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТАЛААР:

Мэдээллийн сан Жолоочийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасан жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой мэдээллийг төвлөрүүлэн нэгтгэх, хяналт тавих үндсэн үүргээ өөрсдийн боловсруулж, нэвтрүүлсэн МИИС системээр хэрэгжүүлж, төлөвлөгөөт зорилтыг бүрэн хангах түвшинд хөгжүүлэлт хийсэн болно. Өөрийн боловсруулсан програм хангамжийн хүрээнд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагааны статистик тайлан гаргаж хэвшсэн болно. Жолоочийн хариуцлагын даатгал эрхэлж байгаа даатгалын 15 компани, 29 даатгалын зуучлагч нараас Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан даатгалын гэрээ, мэдүүлгийн маягтаар 2022 онд **744,973** даатгуулагчийн мэдээлэл, **32,444** хохирогчийн **28,558,627,250** төгрөгийн нөхөн төлбөрийн мэдээллийг хүлээн авч жолоочийн даатгалын мэдээллийн сан нийтдээ **6,990,793** даатгалын гэрээ, **307,853** нөхөн төлбөрийн мэдээлэлтэй боллоо.

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн Дата өгөгдлөөр нэгдсэн тайлан, мэдээг улирал, хагас жил, жилээр гаргаж байна. Үүнд:

- 2022 оны жилийн эцсийн байдлаар жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгалын компаниуд 744,973 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 39,424,455,734 төгрөгийн даатгалын хураамжийн орлого бүрдүүлсэн байна. Даатгалын гэрээг ангиллаар авч үзвэл хувь хүний 542,250, хуулийн этгээдийн 184,647, мэргэшсэн болон С, D ангиллын жолоочийн 15,473, дамжин өнгөрөхийн 2603 гэрээ тус тус байгуулагдсан байна.
- Жолоочийн даатгалын хувь хүний 24263 гэрээ, хуулийн этгээдийн 12,056 гэрээ, мэргэшсэн, CD ангиллын 502 гэрээ, дамжин өнгөрөх 35 даатгалын гэрээ цуцлагдсан байна. Нийт гэрээний 4.95% буюу 36,856 гэрээ цуцлагдсан байна. Цуцлагдсан гэрээний нийт үнийн дүн 2,102,082,260 төгрөг байна.
- Жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчид 2022 онд 32,444 даатгалын тохиолдолд 28,558,627,250 төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өнгөрсөн оны даатгалын тохиолдлын тооноос 6503 хүн, олгосон нөхөн төлбөр нь 10,1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хохирлыг эрсдлийн ангилал тус бүрийн хувьд авч үзвэл тээврийн хэрэгсэлд хохирол учруулсан 31928 даатгалын тохиолдолд 27,8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, бусад хөрөнгөд хохирол учруулсан 407 даатгалын тохиолдолд 558,2 сая төгрөгийн нөхөн төлбөр, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан 109 даатгалын тохиолдолд 242,9 сая төгрөгийн нөхөн төлбөр тус тус олгосон байна.

- ЦЕГ-ын зөрчлийн сангаас АЖДХ-ны МИИС системд зам тээврийн ослын 14,763 тодорхойлолтыг цахимаар бүртгэж, холбогдох гишүүн байгууллагуудын шуурхай албаны ажилтнууд, нөхөн төлбөрийн ажилтнуудыг зам тээврийн ослын мэдээллээр хангасан байна. Энэхүү цахим бүртгэл нь 2022 оны жилийн эцсийн нийт 32444 даатгалын тохиолдлын 45,5 хувийг эзэлж байна.
- 2022 оны жилийн эцсийн байдлаар жолоочийн даатгалд хамрагдалт өнгөрсөн онтой харьцуулахад гэрээний тоо 6.6% -иар төвлөрүүлсэн хураамж 8,8 хувиар өссөн байна.
- Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 29 зуучийн компани 2022 онд жолоочийн даатгалын 237,797 гэрээ байгуулж, 11,806,537,011 төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлж, нийт хураамжийн дүнд 29.9 хувийг эзэлж байна.
- Мэдээллийн санд 2022 онд бүртгэгдсэн хувь хүний жолоочийн даатгалын гэрээний мэдээлэлд шалгалт хийлээ. Шалгалтаар даатгалын компаниудын 476,423 гэрээний мэдээллийн 78 хувь нь бүрэн, 22 хувь буюу 104,874 гэрээний мэдээлэл дутуу оруулсан байна. Мэдээлэлд даатгуулагчийн жолооны үнэмлэхний дугаар, жолоочийн хаяг зэрэг мэдээлэлийг дутуу оруулсан байна.

Цаашид жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчид болон зуучлагч компаниуд “Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн мэдээлэл болон МИИС систем ашиглах гэрээ”-ний 4.2.5-д заасан “жолоочийн даатгалын гэрээ, нөхөн төлбөр, үзлэгийн тэмдэглэл, даатгалын дуудлагын мэдээллийг улирал бүр мэдээллийн сантай тулгалт хийх, зөрүүг тухай бүр арилгах” үүргийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

2022 онд зуучлагч болон даатгалын компаниудад нийт 48 даатгалын бүртгэлийн эрх МИИС системд нээлээ.

Хэрэглээний программ “Microsoft Office 365” ын лиценз авах, лицензийг ашиглаж байгаа компьютер, техник хэрэгслүүдэд суулгаж, МИИС системийн өндөрлөгөөг 2022 оны 12 дугаар сарын 31-нээр авч шинэ оны бүртгэл эхлүүлсэн бөгөөд 2022 оны мэдээ, тайланг тогтсон хугацаанд авч файл үүсгэн хадгаллаа.

Даатгалын гэрээний хугацаа дууссан тохиолдолд улсын дугаар, регистерийн дугаараар лавлагаа гаргаж цахим даатгал хийх боломж олгох лавлагааны сервисийг нэмж хөгжүүлэн ашиглалтанд оруулснаар Тэнгэр даатгал ХХК-ний хүсэлтийн дагуу мобайл болон өөрийн веб сайтаар дамжуулан даатгал хийх боломж нээж өгөв. Мастер шийдэл зуучлагч, Ард, Нэйшнл иншуранс брокерэйж сервисэс, Амарди дижитал, Медиа айдиа консалтинг, Мөнх даатгал, Миг даатгал компани тавьсан хүсэлтийн дагуу цахим даатгал хийх бэлтгэл ажлын хүрээнд компаний зүгээс хөгжүүлэлт хийх чиглэл өгч бэлтгэл ажлыг хангуулах шатанд байна.

Жолоочийн даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн мэдээллийг Нийслэлийн засаг даргын тамгын газартай гэрээ байгуулан төрийн мэдээллийн ДАН системээр танилтыг баталгаажуулан даатгуулагч хүссэн үедээ smartcar.mn системээр авах боломжыг нээж системийн хөгжүүлэлт хийж ашиглалтанд оруулав.

Асимон зууч ХХК-ний хүсэлтээр КИОСК болон ПОС машинаар хийгдэх жолоочийн хариуцлагын даатгалын төрөлд шинээр нэмэгдэж байгаа дамжин өнгөрөх даатгалын гэрээ байгуулахад шаардлагатай тест, туршилтыг хийж хэрэглээнд нэвтрүүлэхийн зэрэгцээ мэдээллийн санд хандах хандалтын бүртгэл хяналтыг сайжруулах, дуудлагын, мөн төрийн банкны сервис, нөхөн төлбөрийн хяналтын хэсгүүдэд нэмэлт сайжруулалт, хөгжүүлэлтийг хамтран хийв.

Байгууллагын цахим хуудсанд www.ami.mn цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл болон 2021 он, 2022 оны улирлын үйл ажиллагааны тайлан, Санхүүгийн тайланг тухай бүр нийтлэн, хэвийн ажиллагаа, хандалтын статистик тайлан, даатгуулагчдад даатгалын гэрээ нь хүчинтэй эсэх, ямар даатгалын компанид даатгалтай тухайгаа www.portal.smartcat.mn сайтаар дамжуулан шалгах боломжтой болгож дурдсан сайтруу орох “Даатгал шалгах” холбоос цэсийг ami.mn сайт дээр байршууллаа. 2022 оны 02-р сарын 08-ны өдөр Үндэсний дата төв дээр байрлах нөөц сервер болон сүлжээний төхөөрөмжүүдэд хандах хандалт тасарсан тул холбогдох арга хэмжээг авч хэвийн ажиллагаанд орууллаа.

МИИС системд зарим хөгжүүлэлт хийснээр даатгалын тохиолдол гаргаж давтан нөхөн төлбөр авсан жолоочийг насны ангиллаар, судалгааны тайлан гаргах боломж бүрдүүлэв.

Мөн, МИИС системийн датабаазаас Даатгуулагчийн тоо /тээврийн хэрэгслийн ангилал тус бүрээр даатгалын хураамж төлсөн хэмжээгээр ангилж тайлан гаргах, Даатгуулагчийн 2012-2021 он хүртлэх даатгуулагчийн И2 ийн утгаар тайлан гаргах боломжтой боллоо.

МИИС системээс цагдаагийн тодорхойлолтыг хүлээн авсан даатгалын компаний нэрээр ангилж тайлан гаргадаг болов. Мэдээллийн сангийн өгөгдөл хадгалах Оракл системийн талаар үйлдвэрлэгчийн төлөөлөлтэй суппорт сунгалт, лицензын талаар уулзалт хийж тулгамдаж байгаа асуудлыг хамтран шийдвэрлэхээр тохиролцон холбогдох мэдээллээр хангаж ажиллалаа. Мөн Холбооны нийт ажилтнуудад “Кибер аюулгүй байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулж ажилтнууд бүрэн хамрагдлаа.

ГУРАВ. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ ИРГЭДЭЭС ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫГ ШУУРХАЙ ҮНЭН ЗӨВ ТОДОРХОЙЛОХ, НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ШУУРХАЙ АЛБА НЬ: Жолоочийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д заасны дагуу жолоочоос шалтгаалан гарсан зам тээврийн ослын талаарх мэдээллийг даатгуулагч, даатгагч, жолооч, хохирогч, иргэнээс хүлээн авч, даатгалын тохиолдлын улмаас хохирогчид олгох нөхөн төлбөрийг шуурхай, үнэн зөв тодорхойлох боломжийг бүрдүүлэн ажиллана гэж заасны дагуу сангийн шуурхай албаны ажиллах журмыг Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-ны 2015 оны 47 дугаар тогтоолоор баталсныг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Сангийн шуурхай алба нь жолоочийн даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дуудлагын ажилтанг ажиллуулах, даатгалын тохиолдлын газар дээр шуурхай очиж үзлэг хийх, тэмдэглэл үйлдэх, даатгалын тохиолдол болсныг баримтжуулах, даатгагч, жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгох нөхөн

төлбөрийг үнэн зөв, тодорхойлж ажилладаг. Сангийн шуурхай албаны дуудлагын нэгдсэн төвд ашиглаж буй техник, технологийн /CallPro system/ давуу талдаа тулгуурлан өнгөрсөн жилүүдийн дуудлагын нийт тоо 24 цаг тутмын дуудлагын тоонд дүн шинжилгээ хийж, дуудлага хүлээн авах боломжийг бууруулахгүйгээр 24/7 горимыш алдагдуулахгүйгээр 4 ээлжийн операторыг 1 болгож зардлын хэмнэлт гаргасан. Сангийн шуурхай албаны оператор нь зам тээврийн осол /ЗТО/ буюу даатгалын тохиолдол нь жолоочийн даатгалын сангаас үйлчилгээ авах эсэхийг тодорхойлж шаардлагатай арга хэмжээг авч, жолооч, хохирогчдыг үнэн зөв зөвлөгөө мэдээллээр хангах үүрэг хүлээдэг. Мөн, даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа дууссан жолооч зам тээврийн ослын улмаас бусдад хохирол учруулсан тохиолдолд даатгалын тохиолдлын газар дээр ажиллаж, хуульд заасан хугацааны дотор хүүгүй, барьцаагүй нөхөн төлбөрийг жолоочийн даатгалын сангаас олгох, санал боловсруулж холбогдох хүмүүст танилцуулж хохирогчийг хохиролгүй болгох, Жолоочийн даатгалын тухай хуулийн 20.2-т зааснаар жолоочийн даатгалын санд эргүүлэн төлөх үүрэгтэйг ойлгуулан нөхөн төлбөр авах тохиолдолд буруутай этгээдтэй гэрээ хийж буцаан төлөлтийн хэрэгжилтийг хангаж байна.

Шуурхай алба нь хууль, журамд заасан үндсэн үүргээ бүрэн биелүүлэхийн зэрэгцээ нийт даатгагч, даатгуулагч нарт түргэн шуурхай үйлчлэх, тэдний ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв, Тээврийн цагдаагийн албаны алба хаагчидтай нягт хамтын ажиллагаатай ажиллаж зам тээврийн ослыг бууруулах, даатгалд хамрагдалтыг сайжруулах ажлыг санаачлан тодорхой хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Даатгалын сангийн Шуурхай алба нь 2022 онд холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн ажиллалаа.. Үүнд:

Албан журмын даатгагчдын холбооны ажлын байранд дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр тутмын ажилд хэвшүүлж, хяналт тавьж ажиллахын зэрэгцээ орон нутаг дахь салбаруудын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг тогтмол хянаж, холбогдох хууль, дүрэм, журам зааврыг мөрдүүлэх үйл ажиллагааг хэвшүүлэх арга зүйн зөвлөгөөг онлайн хуралдаанаар орон нутаг дахь салбарын менежерүүдэд өгч уулзалт зохион байгуулж санал солилцож ажиллалаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтын тайланд дурьдсан Жолоочийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйл зүйлийн 16.5-д Даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэхтэй холбогдон гарах зардлыг даатгагч, жолоочийн даатгалын сан хариуцна гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулахаар Албан журмын даатгагчдын холбооны Гүйцэтгэх захирлын 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02/25 тоот тушаалаар “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгохыг хүссэн хохирогчийн өргөдлийн маягт”, “Даатгалын тохиолдлын буруутай этгээдийн өргөдлийн маягт”-ыг шинэчлэн батлуулж, олон нийтэд мэдээлж ажиллалаа.

Орон нутаг дахь салбаруудын болон шуурхай албаны автомашины явах эд ангийн болон тос солих засвар үйлчилгээ, даатгал, татвар, оношилгоог цаг хугацаанд нь хийлгэж хэвшүүллээ. Санхүүгийн зохицуулах хорооноос Албан журмын даатгагчдын

холбооны үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтын тайлангийн “Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийн” 13-т ... “аймаг орон нутаг дах салбарын менежерүүд даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авах гар утастай байгааг нэгтгэж 18001177 дугаарт дуудлага хүлээн авах боложтой эсэх” гэсэн асуудлыг Холбооны орон нутгийн менежерүүд, Шуурхай албаны дарга, ажлын албаны дугааруудыг 2022 оны 8 сарын 1-ны өдрөөс зогсоож бүх дуудлагыг 18001177 дугаарт төвлөрүүлэн хариу өгч ажиллалаа.

Даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 4 дүгээр сард улсын хэмжээнд аймаг бүрийн тээврийн цагдаагийн хэлтэс, тасаг, даатгалын компаниудын салбаруудтай хамтран хяналт шалгалт, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилго бүхий аяныг 21 хоногийн хугацаанд зохион байгуулж, Аяны хүрээнд 11,805 тээврийн хэрэгсэл шалгалтанд хамруулж жолоочийн хариуцлагын даатгалгүй замын хөдөлгөөнд оролцсон 1,205 тээврийн хэрэгслийн өмчлөгчийг газар дээр нь даатгалд хамруулсан нь Тээврийн цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах нь зохих үр дүнгээ өгч байсныг илтгэнэ. Мөн автомашиныг лизинг, зээлээр худалдан борлуулдаг ББСБ-дад албан журмын даатгалтай холбоотой зөрчлийн мэдээллийг хүргүүлснээр 2022 оны 5 дугаар сард тухайн ББСБ-ын нэр дээр бүртгэлтэй 29,987 тээврийн хэрэгслийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулсан, Жолоочийн хариуцлагын даатгалгүй тээврийн хэрэгслийн мэдээллийг МИИС системээр шүүн шалгаж 700 орчим тээврийн хэрэгслийн өмчлөгч-жолооч нарт хариуцлагын даатгалгүйгээр замын хөдөлгөөнд оролцож зөрчил гаргаж байгааг утсаар нь холбогдож даатгуулагчид анхааруулснаар даатгалд хамрагдалт нэмэгддэг байлаа. Гэвч, 2022 оны 1 дүгээр улиралд СЗХ-оос Холбооны 2019-2021 оны үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтын тайлангийн “Шалгалтаар илэрсэн алдаа, дутагдал” хэсгийн 4.4-т “Жолоочийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26,3-т “Энэ хуулийн 5.1-5.3 дахь хэсгийн заалтын хэрэгжилтэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын алба болон автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус хяналт тавина” гэж заасан тул Холбоо дээрх үүргийг хэрэгжүүлж даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэх, түүнд зориулж зардал гаргасан гэж буруутгасан тул Тээврийн цагдаатай хамтран ажиллах, ЗХУТ-ийн мэдээ, мэдээлэл, камерын хяналтаас даатгалгүй замын хөдөлгөөнд оролцож яваа жолоочийн талаарх мэдээллийг авч даатгалд хамруулах зэрэг ажил цаашид хэрэгжих боломжгүй болсон.

МИИС системээс зөрчилтэй тээврийн хэрэгсэл рүү сануулах мессэж явуулах ажил эхэлсэнтэй холбогдуулан Мобиком, Юнител, Скайтел, ЖиМобайл компаниудтай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу жолоочоос шалтгаалан гарсан зам тээврийн ослын **4402** дуудлага МИИС системд бүртгэгдсэнээс дуудлагын нэгдсэн төвийн шуурхай утсаар 272 даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авч хариу өгчээ.

Жолоочийн даатгалын мэдээллийн сан, шуурхай албаны 70121177, 70101177, 1800-1177 утсаар жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой 10690, орон нутаг дахь салбаруудад 1857, нийт 12547 лавлагаа, мэдээлэл хүлээн авч холбогдох хариу өгч ажилласан байна. Дуудлагыг төрөлжүүлэн ангилбал:

Хүснэгт 3

Хууль тогтоомжийн Лавлагаа	МС-ийн лавлагаа	ДС, нөхөн төлбөрийн лавлагаа	Даатгалын тохиолдлын дуудлага	Даатгалын гэрээ, д/к-ийн утас, байршил	Бусад /санал гомдол	Нийт
386	6729	933	272	1241	1129	10690
Орон нутаг дахь салбаруудад хүлээн авсан дуудлага						
227	434	100	23	311	762	1857

Сангаас олгосон нөхөн төлбөрийг санд буцаан төлүүлэхэд онцгой анхаарч байна. 2021 оны эцсийн байдлаар жолоочийн даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийн эргэн төлөлтийн үлдэгдэл 43 үүрэг гүйцэтгэгчид холбогдох 77,2 сая төгрөг байсан бол 2022 онд нөхөн төлбөр олголт 43 үүрэг гүйцэтгэгчийн 140,0 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд нөхөн төлбөрийн хариуцагчдаар 69,1 сая төгрөг үүнээс 11 үүрэг гүйцэтгэгч нөхөн төлбөрөө бүрэн төлж (5,5 сая нь 3 болон түүнээс дээш жил төлөөгүй хариуцагчдынх) 2022 оны эцсийн байдлаар нийт /2013 оноос хойш/ 76 үүрэг гүйцэтгэгчид холбогдох 148,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2022 онд Нөхөн төлбөр хүссэн 47 өргөдөл хүлээн авч 155,3 сая төгрөгийн нөхөн төлбөртэй холбоотой материалыг судалж 43 хохирогчийг хохиролгүй болгож, хохирогч болон буруутай этгээдэд холбогдох хууль, журмын дагуу хариу мэдэгдэж ажилласан.

Нөхөн төлбөр хугацаандаа буцаан төлөөгүй үүрэг гүйцэтгэгч, тэдгээрийн батлан даагчдаас эрэн сурвалжлагдаж буй 12, шүүхийн шийдвэртэй 2, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газарт шилжүүлсэн 4, шүүхээр эрэн сурвалжлуулахаар шүүхэд шилжүүлсэн 11 -ээс 6-г хэрэгсэхгүй болгож буцаасан байна.

Монгол банкны зээлийн мэдээллийн санд нөхөн төлбөрийн үлдэгдэлтэй бүх хариуцагч, батлан даагчдын мэдээллийг оруулсан. Мэдээллийн сангийн МИИС системд байгаа мэдээлэл, гэрээнд байгаа бүртгэлтэй хаягийн дагуу Нийслэлийн 50 хороогоор орж төлбөр хариуцагчийн оршин суугаа хаягийн бүртгэлийг тулгаад байна.

Орон нутаг дахь салбарын менежерүүд хохирлын хэмжээ бага (5, 10 саяын 50% хүртэлх) нөхөн төлбөрийг тухайн тухайн орон нутагт нь ажлын албаар хянуулан шийдвэрлэж, олгосон нөхөн төлбөрийг даатгалын санд буцаан төвлөрүүлдэг бөгөөд тайлант хугацаанд Өмнөговь аймагт 1,2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг буцаан төлүүлсэн байна. 2022 онд 9 аймаг дахь салбарт даатгалын тохиолдлын 23 дуудлага ирсэн ч буруутай этгээд хохирлыг өөрөө барагдуулсан, эсвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсаныг тогтоосон тул даатгалын компаниудад шилжүүлсэн байна.

2022 онд, ЦЕГ-аас МИИС системд тээврийн хэрэгслийн ослын 14,763 зам тодорхойлолтыг цахимаар бүртгэж, гишүүн байгууллагуудын шуурхай албаны ажилтнууд, нөхөн төлбөрийн ажилтнууд, хүсэлт гаргасан жолооч нарыг зам тээврийн ослын мэдээллээр хангасан байна.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ БУЮУ ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР:

Жолоочийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлд “Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг зас, тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт сурталчилгааг санхүүжүүлэх” гэж заасан байна. Энэ үүргийг хэрэгжүүлэхийн тулд хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай сурталчилгааны гэрээ байгуулж хамтран ажиллаа. 2022 онд сургалт сурталчилгааны зардалд зориулан батлагдсан төсвөөс 116270,9 мян.төгрөг зарцуулсан байна.

2022 онд, Ийгли бродкастинг телевиз, ТВ9 телевизийн “Гарц” нэвтрүүлгийг бэлтгэн хүргэдэг “Дижитон” студи, Монголын хамгийн олон сонсогчтой, “Эм жи эл” радио ньюс 88.3, автордио 96.3, Цахим хэрэглээний чадавхийг дэмжих төв болон “Ган үзэгтэн” ХХК зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж олон нийтэд хүргэх сурталчилгааг түгээн дэлгэрүүлэх, хамтын ажиллагааны хөтөлбөрийг баталж хөтөлбөрийн дагуу сурталчилгааны шторк контентуудыг бэлтгэн биелэлтийг ханган ажиллаж байна.

Ийгл бродкастинг телевиз: Даатгуулагч, Замын хөдөлгөөнд оролцогч нарт зориулсан хөтөлгөчийн зөвлөмж контентийг хоногт 3 удаагийн давтамжтайгаар 2022 оны эхний 9 сард тогтмол 18 цагт эфирээр цацаж, Жолоочийн даатгалын хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллэл өгөх зорилго бүхий хар титрийг хоногт 250-300 удаагийн давтамжтайгаар 3 сарын 1-ээс үзэгчдэд хүргэж байна.

ТВ9 телевизийн “Гарц” нэвтрүүлэг: ТВ 9 телевизээр Долоо хоног бүрийн бямба гаригт цацагддаг Гарц нэвтрүүлэгт 3 сарын 28-аас эхлэн нийт 10 удаагийн дугаарт Даатгалын сангаас 2 удаа, Мэдээлийн сангаас 1 удаа, Шуурхай албанаас 2 удаа оролцож Жолоочийн даатгалд хамрагдалт, хэрэгжилт, жолоочийн хариуцлагын даатгалтай болон даатгалгүй жолоочийн хүлээх үүрэг, Холбооноос хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, хүүхдийг зам тээврийн ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, ярилцлага өгч Тээврийн цагдаагийн байгууллага, Авто тээврийн үндэсний төв, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албанаас хариуцсан ажил үүргийн дагуу, улсын хэмжээнд явагддаг тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоо, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх тухай мэргэжлийн ажилтныг нэвтрүүлэгт оролцуулж олон нийтийг мэдээллээр хангах ажил хийсэн байна. Түүнчлэн гарц нэвтрүүлгийн дугаар бүр дээр Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх шторкуудыг 1-2 удаа цацаж даатгагч, жолооч, иргэдэд анхааруулж ажиллалаа.

Эм жи эл” радио ньюс 88.3: Жолоочийн даатгалын тухай хуулиар “Радио Зөвөлгөө”, “Радио хөтөч” гэсэн 2 төрлийн контентийг бэлтгэж Радио хөтөч-ийг 4 сарын 1-ний өдрөөс эхлэн өдөр бүрийн 07:04, 14:04 цагуудад нийт 244 удаа , Радио зөвөлгөөг мөн 4 сарын 1-ний өдрөөс эхлэн өдөр бүрийн 10:57, 18.57, 20:57 минутанд тогтмол цацагдаж байна. Тайлант хугацаанд Радио зөвлөгөө контентийн 33 эхийг шинээр боловсруулсан байна. 2 төрлийн контент нь 2022 оны туршид нийт 864 удаа цацагдаж нийтийн хүртээл болсон байна.

Автордио 96.3: Тус радиотой хамтарч “Жолоочийн даатгалын цаг” шууд нэвтрүүлгийг бэлтгэн сард 2 удаа явуулж байна. Тус нэвтрүүлэг Даатгалын сан, Мэдээллийн сан,

Шуурхай албанаас оролцож Холбооны үйл ажиллагаа, Жолоочийн даатгалын ач холбогдол, Жолоочийн даатгалын мэдээллийн сан, шуурхай албаны үйл ажиллагаа, нэгдсэн дуудлагын төв, АЖД апп, Даатгалын тохиодлын үед буруутай этгээдийн хүлээх үүрэг, Жолоочийн даатгалын сангаас олгох нөхөн төлбөрийн тухай зэрэг сэдвээр нийт 7 удаа, Тээврийн цагдаагийн албанаас 2 удаа оролцож Замын хөдөлгөөний соёл, явган зорчигчийн замын хөдөлгөөнд оролцох эрх үүрэг сэдвийн хүрээнд шууд нэвтрүүлгийг явуулж сонсогч нарын сонирхсон асуултуудад хариулт өгч оролцсон.

Гишүүдийн үйл ажиллагааг даатгуулагч нарт хүргэх, сурталчлах ажлын хүрээнд 30 минутын шууд нэвтрүүлэгт Ард даатгал, Бодь даатгал, Агула даатгал, Миг даатгал, Монгол даатгал, Практикал даатгал, компаниудын төлөөллийг тус бүрийг долоо хоногт хоёр удаагийн шууд нэвтрүүлэгт оруулж компанийхаа тухай болон Жолоочийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн Жолоочийн даатгалын тухай хуулиас сэдэвлэн 60 секундын 10 шторкийг бэлтгэн өдрийн 10 удаагийн давтамжтай /өдөр бүрийн 07:20,07:40, 08:20, 08:40, 11:20, 12:40, 13:20, 17:40, 19:00, 20:00 / цацаж иргэд, даатгуулагч, жолооч нарт мэдээлэл өгч байна.

Цахим хэрэглээний чадавхыг дэмжих төв: Цахим хэрэглээний чадавхыг дэмжих төвтэй хамтран сошиал орчинд даатгуулагч, жолооч, иргэд олон нийтэд жолоочийн даатгалын ач холбогдол, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, Холбооны үйл ажиллагааг таниулахад чиглэсэн зурган постер хийж Холбооны болон орон нутаг дахь салбаруудын facebook-д, хамтран ажилладаг хэвлэл, мэдээллийн байгууллагуудын сошиал мэдээний сувгуудад байршуулан нийтийн хүртээл болгож байна. Дээрх бэлтгэсэн контентийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд тус төвтэй хамтран ажиллах гэрээг байгуулж QR код бүхий цахим зөвлөмжийг бэлэн болгоод байна.

Тавхан хором хүлээе төсөл: Ган үзэгтэн ХХК-н Zarig.mn, Зам тээвэр хөгжлийн яам, Тээврийн цагдаагийн алба зэрэг байгууллагуудтай хамтран нийт 150,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Тавхан хором хүлээе” төслийг 3 сарын 21-ээс 5 сарын 25-ны өдрийн хооронд хамтран зохион байгуулж ажиллалаа. Холбооны зүгээс хэвлэлийн бага хурал хийх, 2 удаагийн хэлэлцүүлэг, тараах материалууд, зурган постеруудын эх бэлтгэх, хэвлэх зэрэг ажлыг хариуцаж ажилласан. Төсөл хэрэгжих хугацаанд давхардсан тоогоор нийт 4 сая хүнд мэдээ мэдээлэл хүргэж ажиллажээ. Улаанбаатар хотын Нийтийн тээврийн 100, хот хоорондын нийтийн тээврийн 770 автобусны гадна талд 5 төрлийн сэрэмжлүүлэх зурган мэдээлэл, постерыг байрлуулж, зорчигчдод 30800 ширхэг сэрэмжүүлэх материалыг тараалаа.

Монголын даатгалын зуучлагчдын холбооноос жил бүр явуулдаг Зуучлагчийн эрх олгох сургалтад “Жолоочийн даатгалын тухай хууль”, хэрэгжүүлэхэд даатгалын мэргэжлийн оролцогчдын анхаарах асуудал сэдвийн хүрээнд 3 дугаар сард орон нутагт зохиогдсон сургалтуудад онлайнаар оролцож сургалт явуулж, мэдээлэл өглөө.

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд замын хөдөлгөөнд оролцох соёл, Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, Жолоочийн даатгалын ач холбогдлыг

ойлгуулах сургалтыг 4-5 саруудад Нийслэлийн чингэлтэй дүүргийн 5 дугаар сургууль, Баянзүрх дүүргийн 21 дүгээр сургууль, Сүхбаатар дүүргийн “Шинэ үе” сургуулиудын дунд ахлах ангийн хүүхдүүдэд нийт 6 удаагийн сургалт явуулав.

Жолоочийн хариуцлагыг өндөржүүлэхэд зөвхөн сургалт сурталчилгаа явуулах нь хангалттай нөлөөлөл үзүүлэхгүй болох нь өнгөрсөн хугацааны статистик тоо харуулж байна. Цаашдаа жолоочийг хариуцлагажуулахад мэргэжлийн байгууллага /сургалтын/ төрийн хяналт тавих үүрэг бүхий гүйцэтгэх засаглалын бүх шатны байгууллагуудын хамтын ажиллагааг эрс сайжруулж зөрчилд ногдуулах торгуулийн хэмжээг эрс нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

Б. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ, ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАРЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:

Албан журмын даатгагчдын холбооны Гүйцэтгэх захирлын 2017 оны 02/53 дугаар тушаалаар “Албан журмын даатгагчдын холбооны орон нутаг дахь салбарын ажиллах журам”-ыг баталсан. Орон нутагт салбар байгуулж ажиллуулсан гол зорилго нь Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг сурталчлах, даатгалд хамрагдуулалтыг нэмэгдүүлэх Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр авах даатгалын тохиолдлын холбогдох үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдсэн хяналт шалгалт хийхэд оршиж байлаа. Орон нутгийн салбар зорилгоо үндсэндээ хэрэгжүүлсэн гэж үзэж болохоор байгаа учир зардал хэмнэх зорилгоор салбаруудыг татан буулгах нь зохистой байгааг тэмдэглэж байна.

Орон нутгийн салбарын үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломж бүрдсэн гэж үзэж байна.

2022 онд орон нутаг дахь салбарууд журамд заасан чиг, үүргийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- Эхний хагас жилд Аймгийн цагдаагийн газрын дэргэдэх Замын цагдаагийн тасагтай нягт уялдаа холбоотой ажиллаж даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтарсан хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, тээврийн хэрэгслийн улсын үзлэг оношлогооны үеэр сумдад томилолтоор ажиллан үзлэгт орж буй тээврийн хэрэгсэл жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан эсэхэд хяналт тавих, даатгалд хамруулах зэрэг ажлыг гүйцэтгэж байсан боловч Санхүүгийн зохицуулах хорооноос хийсэн шалгалтын тайлан, дүгнэлт, зөвлөмж болон СЗХ-ны Хяналт шалгалт, зохицуулалтын газраас өгсөн чиглэлийн дагуу энэ чиглэлийн үйл ажиллагааг сүүлийн хагас жилд зогсоосон.

- Зам, тээвэр хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг шинэчлэн баталсан. Журмын шинэчлэлтээр тээврийн хэрэгслийн бүртгэл хийхэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг заавал шалгах шаардлагагүй болсон нь хуулийн хэрэгжилтэд сөрөг нөлөөлөл үзүүлж эхэлсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдад Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан бичиг удаа дараа хүргүүлсний үр дүнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/136 тоот “Журамд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай” тушаалаар “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-д өөрчлөлт оруулсан. Салбарын менежерүүд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/136 тоот журмыг Авто тээврийн төвийн дарга, мэргэжилтнүүдэд танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах нөхцлийг бүрдүүлсэн.

- Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд салбарын менежерүүд ажиллаж зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн тээврийн цагдаагийн тасагтай хамтран ажилласан.

- Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр авсан орон нутагт оршин суух хаягтай иргэдээс буцаан нэхэмжлэх ажлыг салбарын менежерүүд хариуцан ажиллаж 3,950,000 төгрөгийн нөхөн төлбөрийг жолоочийн даатгалын санд буцаан төлүүлсэн байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ:

- Жолоочийн даатгалын тухай хууль 2011 онд батлагдаж 2012 оноос хэрэгжсэн өнгөрсөн хугацааны үйл ажиллагаанд судалгаа хийж, хуулийн зорилго хэрхэн хэрэгжиж байгааг дүгнэж хуульд зарчмын өөрчлөлтүүд оруулах шаардлагатай болсон байна.

- Холбоо даатгагч, даатгуулагч, хохирогч, зуучлагчид жолоочийн хариуцлагын даатгалыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоо, ашиг сонирхлыг хангаж жолоочийн хариуцлагын даатгалын гэрээг байгуулах, даатгалын тохиолдол, нөхөн төлбөр, дуудлага мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл солилцох, даатгалын тохиолдлыг шуурхай, үнэн зөв тодорхойлох, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт сурталчилгааг санхүүжүүлэх, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж МИИС системийг өргөжүүлэн хөгжүүлж жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ хийх үйл ажиллагааны 86% хувийг бүрэн цахимжуулж, жолоочийн хариуцлагын даатгал цахимаар хийх боломж бүрдүүлэн АЖД мобайл аппликейшнийг нэвтрүүллээ. Албан журмын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад мэдээллийн үйл ажиллагааг бүрэн чиглүүлж даатгагчдаас төвлөрүүлсэн хөрөнгийг бүрэн зориулж байгаа төдийгүй бусад эх үүсвэрээс ч хөрөнгө зарцуулж байна

Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу Жолоочийн даатгалын сангаас өнгөрсөн 10 жилийн хугацаанд даатгалгүй 289 жолоочийн бусдад учруулсан хохирлын 727,293,21.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг хохирогчид олгосон байна. Дээрх тоо баримтаас харахад Жолоочийн даатгалын тухай хуулийн зорилт тодорхой хэмжээнд хэрэгжиж зохих үр нөлөө үзүүлсэн байна. Зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлын үр дүнг хөндлөнгийн, мэргэжлийн, судалгааны байгууллагаар дүгнүүлж цаашид ажиллах чиг баримжааг тодорхойлсон нь жолоочийн хариуцлагын даатгалын зохицуулалт хэр оновчтой байгааг тодорхой болгож өгсөн юм.

Жолоочийн хариуцлагын даатгалыг цахимаар хийх боломжийг бүрдүүлж, ослын тодорхойлолтыг цахимаар солилцдог, замын цагдаад хандахгүйгээр даатгагчтай холбогдон асуудлыг шуурхай шийдвэрлэх гарц, гаргалгаа нээлттэй байгааг даатгагч, даатгуулагчид бүрэн ашиглахад анхаарах нь зүйтэй байна. Ялангуяа зам тээврийн осол

буюу даатгалын тохиолдлыг шийдвэрлэж байгаа одоогийн зохион байгуулалтыг оновчтой болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах олон зүйл заалт байгааг хаана хаанаа анхаарвал зохино. Энэ талаар Санхүүгийн зохицуулах хорооны болон Холбооны Удирдах зөвлөлийн хуралдаан, Холбоонд хийсэн СЗХ-ны шалгалтын ажлын хэсэгт тус тус танилцуулсан болно.

- Өнгөрсөн 11 жилд жолоочийн хариуцлагын даатгалд давхардсан тоогоор 6,392,025 тээврийн хэрэгсэл /дамжин өнгөрөхийг хассанаар/ хамрагдсан бөгөөд 2022 оны эцсийн байдлаар хариуцлагын даатгалд хамрагдалт 70 орчим хувьтай байна. Мөн хугацаанд, 306,1 тэрбум төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлж даатгалын тохиолдлын хохирогч 289586 хүнд 169,2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Даатгалд хамрагдсан нийт даатгуулагчдын 4,5 орчим хувь нь даатгалын тохиолдол гаргаж, төвлөрүүлсэн хураамжийн 55,3 хувийг хохирогчдын нөхөн төлбөрт олгосон байна. Харин 2022 онд энэ хувь 72 хувьд хүрсэн нь анхаарал татаж байна. Өнгөрсөн жилүүдэд даатгалын тохиолдлын хохирогчдод олгосон нөхөн төлбөрийн дундаж 584319 төгрөг байгаа бөгөөд нийт хохирогчдын 86,04 хувь нь нэг сая хүртэл, 1,14 хувь нь 5-10 сая төгрөгийн хохирол нөхүүлсэн байна.

Зам тээврийн ослын улмаас 2012-2022 онд 5545 хүн амь насаараа хохирч, 41315 хүн эрүүл мэндээрээ хохирсон тухай тээврийн цагдаагийн албаны статистик байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хууль хэрэгжсэн өнгөрсөн 11 жилийн хугацаанд дээрх амь насаараа хохирсон хүмүүсийн 8 орчим хувьд нь, эрүүл мэндээрээ хохирсон хүмүүсийн 6 орчим хувьд нь жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулагчдын төлсөн хураамжаас нөхөн төлбөр олгосон байна. Өнгөрсөн хугацаанд зам тээврийн осол гаргасан шалтгааны 97,8 хувийг жолоочийн буруутай үйлдлээс нөлөөлсөн гэж ТЦА-наас гаргасан судалгаа нотолж байна.

- СЗХ-ны 2012 оны 392 дугаар тогтоолоор батлагдсан Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам, СЗХ-ны дарга, ХЗДХСайдын 2019 оны хамтарсан тушаалаар батлагдсан мэдээлэл нийлүүлэх үүргийн биелэлт хангалтгүй байгааг жил бүрийн тайланд дурдаж өмнөх жилүүдийн Удирдах зөвлөлийн хуралдаанд танилцуулагдсан ч дорвитой өөрчлөгддөггүй, байнгын зөрүүтэй мэдээлдэг дутагдлыг Холбооны зүгээс мэдээнд тулгалт хийж, зөрүүг арилгах, мэдээллийн санд нийлүүлэх үүргээ биелүүлэх талаар сануулга, мэдэгдэл, анхааруулга өгсөөр ирсэн. Гэвч зарим нэг даатгагчид биелүүлдэггүй хэвээр байгаа явдалд Жолоочийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавьж мэдээллээ бүрэн гүйцэд мэдээлж мэдээллийн санд нийлүүлэх, зөрүүгүй мэдээ СЗХ-нд хүргүүлдэг болгох талаар арга хэмжээ авахыг хүсч байна.

- Мөн өнгөрсөн жилүүдэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг их хэмжээгээр цуцалж байгаа шалтгааныг судалж үзэх нь зүйтэй байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Ажлын албаны дотоод хяналт хариуцсан
ахлах ажилтан



Б.Эрдэнэцэцэг

ТАЙЛАН БИЧСЭН:

Жолоочийн даатгалын сангийн дарга,
ерөнхий санхүүч
Жолоочийн мэдээллийн сангийн дарга
Даатгалын сангийн шуурхай албаны дарга



С.Хишигзаяа

Т.Шинэцэрэг

Б.Батзориг

ХЯНАСАН:

Албан журмын даатгагчдын
холбооны гүйцэтгэх захирал



Д.ЦЭВЭЭНДЖАВ